



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйлийн 72.1, 72.4 дэх хэсэг, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохион байгуулах үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Ганболд /Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга/

Гишүүд: Д.Отгонтуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Г.Одгэрэл /Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/

О.Ишханд /Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/

Д.Оюунгэрэл /Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга:

Б.Янжинлхам /Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн/

2. Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл хөтлөлтийн холбогдох баримт бичгийг гаргаж өгөхийг нярав Ц.Эрдэнэцэцэгт даалгаж, тооллогын дүнг танилцуулахыг Комиссын дарга /Н.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003212